



ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ ХХК-ИЙН "ТАМСАГ 21", "ТОСОН УУЛ 19"
ТАЛБАЙН ТАЛААР БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ 4, 5 ДУГААР
ЗҮЙЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 10 дугаар сарын
30-ны өдөр

Дугаар 418-АБ/2023-29

Улаанбаатар
хот

АЖЛЫН ЗОРИЛГО: Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хүрээнд "Тамсаг 21", "Тосон Уул 19" талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 4, 5 дугаар зүйлд /Өртөг зардал, хайгуулын үе, хайгуулын хугацааг сунгах, нээлтийн цооногууд, үр ашигтай нээлтүүд болон олборлолтын хугацаа/ заасан зохицуулалтын талаар хууль, эрх зүйн шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

ЗОРИЛТ: Шинжээч нь аудитын тайлагналын үе шат дуусах хүртэлх хугацаанд хариуцсан асуудлаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллана.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2023.10.25- 2023.11.25

БАЙРШИЛ: Үндэсний аудитын газар

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3 дахь хэсэг, УИХ-ын Төсвийн байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан "ТАБ-ын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн аудитыг 2023 оны 03 дугаар сарын 9-ний өдрөөс эхлүүлэн гүйцэтгэж, аудитын тайланг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

БНМАУ /хуучин нэрээр/-ын Бага хурлаас анх 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Газрын тосны тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн дагуу Монгол газрын тосны товчоо (хуучин нэрээр) болон Австралийн Команд Петролиум Лимитед, Монголын Цагаан шонхор ойл корпорац, Соко тамсаг Монголиа.инк компаниудын хооронд "Тамсаг XXI" гэрээт талбайн талаар 1995 оны 12 дугаар сарын 11-ний өдөр, Монгол Газрын тос компани болон Медаллион Монгол Ойл компанийн хооронд "Тосон Уул XIX" гэрээт талбайн талаар 1993 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Бүтээгдэхүүн хуваах гэрээг тус тус байгуулжээ.

Газрын тосны тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр шинэчлэн батлагдсантай холбогдуулан 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Газрын тосны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсон. Засгийн газрын 2014 оны 342 дугаар тогтоолоор "БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам /Засгийн газрын 1991 оны 204 дүгээр тогтоолоор баталсан/, "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" /Засгийн газрын 26 дугаар тогтоолоор баталсан/ тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсон байна.

Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолоор Газрын тосны тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг үндсэн нөхцөлийг нь өөрчлөхгүйгээр Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч нарын хооронд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар”-т нийцүүлэн шинэчлэх арга хэмжээ авахыг эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад даалгасан байна.

Энэхүү хүрээнд Газрын тосны газрын даргын 2016.06.15-ны өдрийн 89, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016.11.21-ний өдрийн А/57, 2018.01.17-ны өдрийн А/12 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд Бүтээгдэхүүн хуваах гэрээг хуульд нийцүүлэн шинэчлэх шаардлагыг гэрээлэгч компанид удаа дараа тавьж ирсэн боловч Газрын тосны тухай хууль шинэчлэн батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчилж байгуулаагүй байна.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

Шинжээч нь Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитаар дараах ажлыг гүйцэтгэнэ.

1. “Тамсаг 21”, “Тосон Уул 19” талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн 4 дүгээр зүйл /Өртөг зардал/-д дүгнэлт өгөх;
2. Тус гэрээнүүдийн 5 дугаар зүйл /хайгуулын үе, хайгуулын хугацааг сунгах, нээлтийн цооногууд, үр ашигтай нээлтүүд, олборлолтын хугацаа/-д аудитын багт шаардлагатай асуудлаар хууль, эрх зүйн туслалцаа үзүүлж, дүгнэлт гаргах;
3. Дээрх 4, 5 дугаар зүйлд заасан зохицуулалттай уялдсан БХГ-ний бусад зүйл, заалтад дүгнэлт өгөх.

ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр газрын тосны олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн “Тосон Уул 19”, “Тамсаг 21” талбайн 2019-2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, тайлан, мэдээ, анхан шатны баримт, Бүтээгдэхүүн хуваах гэрээний 4, 5 дугаар зүйлд заасантай холбоотойгоор АМГТГ болон гэрээлэгчээс ирүүлсэн албан бичиг холбогдох бусад баримт, материалуудыг хамруулан дүгнэлт гаргана.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь аудитын багтай хамтран Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, АДБОУС болон холбогдох бусад эрх зүйн баримт бичигт нийцүүлэн цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэнэ.

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан зорилгыг хэрэгжүүлж, ажил үүргийн хуваарийн дагуу хамрах хүрээний ажлыг холбогдох стандарт, хууль тогтоомжид заасны дагуу аудитын тайлагналын үе шатанд үндэслэл бүхий дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Засгийн газрын 1996 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Тамсаг 21”, 1997 оны 239 дүгээр тогтоолоор баталсан “Тосон Уул 19” талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ, хэлцэл, шийдвэрүүд нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгаа эсэхийг нотолгоонд суурилж үнэлнэ.

Аудитын үр дүнд тулгуурлан Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2019-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын талаарх дүнг бодитой үнэлж, аудитын дүгнэлт, тайлан гаргаж холбогдох байгууллага, олон нийтэд үнэн зөв мэдээлнэ.

ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын аудитын бүрэлдэхүүнтэй хамтран ажиллах бөгөөд, шаардлагатай дэмжлэг туслалцааг тус газраас үзүүлнэ.

Шинжээч нь ажил эхлүүлэх болон ажлын явцад үүсэх хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэн захиалагч /Санхүү-Нийцлийн аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Шинжээч нь дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Шинжээч нь Олон улсын гэрээ хэлцэл, татвар, хууль, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, дүн шинжилгээ хийх, үнэлэх чадвартай, газрын тосны салбарын талаар мэдлэг, дадлага, туршлагатай иргэн, баг, хуулийн этгээд байна.

Үндэсний аудитын газар нь зөвлөх үйлчилгээ үзүүлж чадахуйц, ажлын дадлага, туршлагатай, дүгнэлт гаргах чиглэлээр эрх бүхий шинжээчтэй хамтран ажиллах бөгөөд тухайн аудитад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлж, Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтой хамтран ажиллана.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд зөвлөх нь *Багаар гүйцэтгэж болно!* дараах боловсролын тусгайлсан зэрэг, үндсэн мэргэжил, мэргэшлийн шаардлагыг хангасан байна. Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий;
- Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - Хууль, эрх зүйн магистр, түүнээс дээш боловсрол эзэмшсэн;
 - Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий;
 - Мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай;
 - Гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний үнэн бодит байдлыг хариуцаж, дүгнэлт гаргах эрх бүхий;
 - Англи эсхүл хятад хэлний ахисан түвшний мэдлэгтэй;
 - Төрийн болон албаны нууц, байгууллага, хувь хүний нууцыг чандлан хадгалах чадамжтай;
 - Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай.
 - Ашигт малтмал, уул уурхайн салбар, газрын тосны чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан бол давуу тал болно.

Ажиллах хүчний шаардлага:

- Мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил ажилласан;
- Англи эсхүл хятад хэлний ахисан түвшний мэдлэгтэй;
- Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- Багаар ажиллах, ачаалал даах чадвартай байх.

Баг, хувь хүний хувьд:

- Багаар ажиллах чадвартай, олон улсын гэрээ, хэлцэлд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай;
- Төрийн болон албаны нууц, байгууллага, хувь хүний нууцыг чандлан хадгалах чадамжтай;

- Хууль, эрх зүйн магистр, түүнээс дээш боловсрол эзэмшсэн, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, англи эсхүл хятад хэлний ахисан түвшний мэдлэгтэй;
- Монгол Улсын Олон Улсын гэрээний эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, Олон улсын гэрээнд дүгнэлт гаргахад зөвлөх, шинжээчээр ажиллаж байсан бол давуу талтай;
- Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, шаардлагад нийцүүлэн судалгаа, шинжилгээ хийж байсан, хууль зүйн магадлан шинжилгээ хийж дүгнэлт гаргах чадвартай;
- Хууль, эрх зүйн мэргэжлээр 8 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай;
- Монгол Улсын шүүх, арбитрын маргаанд оролцож байсан туршлагатай;
- Ашигт малтмал, уул уурхайн салбар, газрын тосны чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан бол давуу тал болно.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ, тооцоолол, санал тайлбар, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг цаг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэх үндсэн шаардлагыг хангасан байна.

ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцож, гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.

Төлбөрийг төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсэнд шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.